

ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО
/2018-2028/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Барилгын салбарт тулгамдаж байгаа асуудал, нөхцөл байдлын дүн шинжилгээний гол үр дүн:

Барилгын салбар нь өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд төрийн өмчөөс хувийн хэвшилд бүрэн шилжиж, өмчийн харилцаанд нийцэн төлөвших цаг үеийг туулж, өнөөгийн байдлаар 3.566,0 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх үндэсний чадавхи бүрдсэн байна.

Салбарт нэвтэрсэн техник, технологийн түвшинг гол үзүүлэлтүүдээр үнэлэхэд барилгын үйлдвэрлэлд хөдөлмөр зарцуулалт багасч, техникжсэн ажлын эзлэх хувь хэмжээ өнгөрсөн 10 жилд нилээд нэмэгдэж, барилга барих хугацаа үндсэндээ хоёр дахин богиноссон үзүүлэлттэй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж байна.

Барилгын зураг төсөл, инженерийн судалгааны ажилд ахиц дэвшил гарч, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулалтын түвшин, чанар сайжирч, орчин үеийн нэгдсэн өгөгдлийн санд суурилсан зураг төслийн программчилсан боловсруулалтад шилжсэн нь олон улсын төслийн удирдлага, мэдээллийн цахим системд нэвтрэх, стандартыг мөрдүүлэх боломж бүрдэж байна.

Барилгын салбарын мэргэжилтэн бэлтгэдэг 6 их, дээд сургуулийг 2010 онд 799 мэргэжилтэн төгсч байсан бол 2017 оны байдлаар барилгын салбарын мэргэжлээр улсын болон хувийн хэвшлийн 15 их, дээд сургуульд 72 мэргэжлээр 1480 дээд боловсролтой мэргэжилтэн төгссөн нь 2010 онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, чанарт ахиц дэвшил гарч, сүүлийн 5 жилд 350 гаруй үйлдвэр шинээр ашиглалтад орсноор барилгын өргөн хэрэглээний 40 гаруй нэр төрлийн материалын 70 хувийг дотооддоо үйлдвэрлэх боломжтой болсон.

Сүүлийн арав гаруй жилийн хугацаанд барилгын салбарын бодлого зөвхөн орон сууц, түүний дэд бүтэц рүү чиглэснээр ялангуяа Улаанбаатар хотод олон мянган орон сууц шинээр баригдаж, шинэ дэвшилтэт технологи нэвтэрч, механикжилт, автоматжуулалтын түвшин дээшилж шинэ нэр төрлийн барилгын материал, техник хэрэгсэл ашиглан богино хугацаанд иж бүрэн хороолол барьж байгаа нь томоохон дэвшил юм.

Барилгын зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэх, ханган нийлүүлэх ажиллагаанд тэргүүний техник, технологийг нутагшуулан зарим дэвшил гарч байгаа хэдий ч барилгын салбарын техникийн нэгдсэн бодлогын удирдлага хангалтгүй байна.

Барилгын салбарт нийт 694 стандарт, 284 норм ба дүрэм мөрдөгдөж байгаагаас стандартын 27%, барилгын норм ба дүрмийн 70%, барилгын төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын 75.85% -ийг шинэчлэх шаардлагатай байгаа нь “Барилгын техникийн болон үнэ бүрдэлт, төсвийн норм, нормативын баримт бичгүүд өнөөгийн техник, технологийн түвшинг хангахгүй.” байна.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгагдсан хууль, тогтоомжуудаас боловсруулж батлуулсан хууль, тогтоомж 20 орчим хувь байгаа нь барилгын салбарын хууль тогтоомж болон дүрэм журмуудын шинэчлэлт хангалтгүй хийгдэж байгааг харуулж байна.

Хууль тогтоомжийн салбар дундын уялдаа холбоо сул байгаагаас салбарыг жижиглэн хуваах¹, эрчим хүч, зам, гүүрийн барилга байгууламжийн тусгай зөвшөөрлийг чиглэлийн төрийн захиргааны төв байгууллагаас давхардуулан олгох, ижил төрлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүлээн зөвшөөрөхгүй байх зэрэг салбар дундын зөрчилтэй асуудал байсаар байна.

Барилгын салбарын эрдэм шинжилгээ судалгааны ажлын бодлого, зохицуулалт хангалтгүй түвшинд байна.

Шинжлэх ухаан, технологийн сангаас 2010-2017 онд 270 төсөлд 34.3 тэрбум төгрөгийг зарцуулсан боловч барилга, хот байгуулалтын яамны захиалгаар 449.2 сая төгрөгийн 6 төсөл хэрэгжсэн нь үйлдвэрлэлийн чиглэлийн яамдын захиалсан төслүүдийн тоотой харьцуулахад нэн доогуур үзүүлэлт юм.

Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах эрх бүхий байгууллагуудын тоо нэмэгдсэн боловч зохион байгуулалт, үйл ажиллагаа нь тогтворжсон аж ахуйн нэгж, байгууллага цөөн байгаа нь зураг төслийн байгууллагуудын чадамж, менежмент, дотоод хяналтын тогтолцоог дээшлүүлж тооцоолол, зураглал, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Барилгын компаниуд болон материалын үйлдвэрүүд зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, барилгын салбарын үйлдвэрлэл- хэрэглээний тэнцвэрт байдлыг харгалзахгүй, ашиг орлогыг тэргүүнд тавьж шинжлэх ухаанч бус, төслийн удирдлага, эрсдлийн судалгаагүй ажилласнаас зээл-санхүүжилтийн дарамтад орж, бүтээгдэхүүнээ худалдан борлуулж чадахгүй болсноор 1.0 их наяд төгрөгийн хөрөнгөө барьцаалсан 540 тэрбум орчим төгрөгийн зээлийн өртэй, түүний 318.4 тэрбум нь чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлтэй байна.

Зорилтот бүлгийн орон сууцны барилгажилтын бодлого хангалтгүй байснаас зохиомол өндөр үнэтэй орон сууц худалдан авах эрэлт байхгүй болж, 3.4 их наяд төгрөгийн зээл олгогдож, дуусаагүй үйлдвэрлэлд төлөгдөх баталгаагүй 1.3 их наяд төгрөгийн зээл хуримтлагдаад байна.

Мөн барилгын ажлыг материал, түүхий эдээр хангах уламжлалт тогтолцоо өөрчлөгдөөгүй, хангалт, хүргэлт, төлбөр тооцооны зардал ихтэй хоцрогдонгуй арга барил зонхилж, хөгжил байршлыг оновчтой тогтоон тээвэр, ложистикийн системийг нэвтрүүлэн хүргэлтийн үйлчилгээтэй бөөний худалдааны цахим систем бүхий ханган нийлүүлэх үйлчилгээ үгүйлэгдэж байна.

Улсын хэмжээнд 2018 оны байдлаар 1.126.690 ажиллагсад ажиллаж байгаагийн 6,1 хувь буюу 59078 ажиллагсад барилгын салбарт ноогдож байна. Хөдөлмөрийн зах

¹ 1 дүгээр зүйл. Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “зам гүүр” гэснийг хассугай.

зээлийн судалгаагаар барилгын салбарын ажиллах хүчний эрэлт 18.6 мянган хүн байгаа нь худалдаа, үйлчилгээ, боловсруулах үйлдвэр, ХАА-н салбаруудаас өндөр байна.

2017 оны байдлаар мэргэжлийн боловсрол сургалтын 83 байгууллагад 35 831 суралцагч суралцаж байгаагийн 13 825 суралцагч буюу 38.5 хувь барилгын өргөн мэргэжлээр суралцаж байна. Улсын хэмжээнд хамгийн эрэлт хэрэгцээтэй ТОП-20 мэргэжлийн дотор 13 барилгын мэргэжил орж байна.

Салбарын хүний нөөцийн бодлого, зохицуулалт нь нэгдсэн шинжийг агуулж чадахгүй, салбарын мэргэжлийн боловсрол, давтан сургалт, дээд боловсролын одоогийн урсгал байдал нь тулгамдаж байгаа хэрэгцээ шаардлагыг тэр бүр хангахгүй байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээг хэрэгжүүлээгүй цаг алдсан зэргээс шалтгаалан салбарын бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа хямарч, салбарын нэгдсэн удирдлагын тогтолцоо алдагдаж удирдлагын хомсдолд орсон байна.

Барилгын салбар төрийн болон техникийн удирдлага, санхүү, эдийн засгийн хямралд ороод байна.

Орон сууцны талаар төр засгаас хэрэгжүүлсэн бодлогыг гажуудуулан хөөсөрсөн үнэтэй орон сууцыг нийгмийн зонхилох давхаргад зээлээр дамжуулан шахсан нь иргэдийн төлбөрийн чадварыг бууруулж, өрийн дарамтад оруулан, зах зээлийн харилцааны хэвийн нөхцөлийг алдагдуулсан.

Монгол Улсад 2008 оноос хэрэгжүүлж байгаа “Орон сууцны ипотекийн зээлийн систем”-ийн урьдчилгаа төлбөр, хугацаа, зээлийн хүүгийн нөхцөл нь иргэдийн худалдан авах чадвар, үндэсний онцлогт нийцэхгүй зөвхөн банкны ашиг орлогыг нэмэгдүүлж байгаа тул энэ системийг цаашид өөрчлөх шаардлагатай.

Санхүүгийн болон борлуулалтын хүндрэл дарамт нь барилгын компаниудыг улмаар банк санхүүгийн системийг өндөр эрсдэлд хүргэх магадлалтай болсон.

Их, дээд сургуулиар бэлтгэгдсэн ИТА-ны мэргэжлийн чадамж орчин үеийн арга технологид төдийлөн нийцээгүй, зах зээлийн хэрэгцээнд нийцсэн хүний нөөцийн дотоод харьцааг зохистой хангах бодлого төлөвлөлт сул, ажиллах хүчний хэрэгцээг судалгаа тооцоотой шийдвэрлэж чадахгүй байна.

Иймээс барилгын салбарын мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, өөрчлөн сайжруулах, ажлын байрны шаардлагад нийцүүлэн ажиллах хүчнийг бэлтгэхэд салбарын яамнаас онцгой анхаарах шаардлагатай байна.

Салбарын тулгамдсан хэрэгцээ шаардлагад нийцсэн судалгаа шинжилгээний ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлж, өмчийн харилцааны агуулгад нийцсэн “гэрээ захиалга- үр дүн” –гийн зарчмаар ШУТ-ийн болон инновацийн төслүүдийг тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан захиалж, хэрэгжүүлж байх нь салбарын үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

2017 оны суурь түвшин дээр өсөлтийн итгэлцүүр, далд эдийн засгийн нөөц болон статистикт ордоггүй барилгын хэмжээг төсөөлөлд оруулан тооцвол 2020 онд 4.343,0

тэрбум, 2025 онд 8.338,0 тэрбум, 2028 онд 12.330,0 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалт хийх боломжтой байна.

Үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг 7.55 хувьд хүргэж үйлдвэрлэлийн өсөлтийг нэмэгдүүлэн 2020 онд 24%, 2025 онд 79%, 2028 онд 107 хувьд хүргэнэ.

Салбарын төрийн бодлогыг баримтлан хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Монгол Улсын бүтээн байгуулах өнөөгийн чадавхийг 2020 онд 1.38 дахин, 2025 онд 2.6 дахин, 2028 онд 3.9 дахин өсгөх тооцоо төсөөлөл гаргаж, баримт бичгийг боловсруулсан.

Барилгын салбарын эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодитой үйл ажиллагааг тодорхойлсон нэгдсэн бодлого боловсруулж, техник, технологи, хөрөнгө санхүү, хүний нөөцийн бүхий л боломжийг ашиглан тулгамдаж байгаа асуудлууд, нөхцөл байдлын шинжилгээний үр дүнгүүдэд үндэслэн Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д туссан зорилтуудыг хангах замаар салбарын хөгжлийн бодлогыг тодорхойлох шаардлагатай юм.

1.2. Бодлого боловсруулах үндэслэл

Барилгын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”, УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”, Улсын их хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан зорилтууд болон бусад холбогдох хууль, тогтоомж, төсөл, хөтөлбөрийн заалтуудтай уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу “Төрөөс барилгын салбарт баримтлах бодлого”-ыг боловсруулсан.

1.3. Бодлогын хамрах хүрээ

“Төрөөс барилгын салбарт баримтлах бодлого” /2018-2028/ дараахи 6 үндсэн чиглэлийг хамарна. Үүнд:

1. Салбарын удирдлага, хууль эрх зүй, норм, норматив
2. Салбарын шинжлэх ухаан, технологи, инноваци
3. Барилгын салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт
4. Хот байгуулалт, барилгын зураг төсөл
5. Барилгын материалын үйлдвэрлэл
6. Салбарын сургалт, хүний нөөц
7. Орон сууц, нийтийн аж ахуй
8. Газар зохион байгуулалт, геодези зураг зүй

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1. Бодлогын зорилго:

Төрөөс барилгын салбарт баримтлах бодлого нь хот байгуулалт, бүс нутгийн хөгжилд суурилсан барилга бүтээн байгуулалтын хэрэгцээ шаардлага, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах замаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.2. Бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

- 2.2.1. Салбарын удирдлага, зохион байгуулалт, хууль эрхзүй, норм, нормативыг боловсронгуй болгох замаар салбарын хөгжлийг хангана.
- 2.2.2. Салбарын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх арга замыг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно.
- 2.2.3. Барилгын хөрөнгө оруулалтыг тэлж, салбарын үйл ажиллагааг олон улсын хөгжлийн хандлагад нийцүүлнэ.
- 2.2.4. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд суурилсан хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулах ажлыг олон улсын түвшинд хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.2.5. Эх орны эрдэс баялгийн нөөцийг зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, салбарыг чанартай материалаар хангах бодлогыг тодорхойлно.
- 2.2.6. Салбарын мэргэжлийн сургалтын хөтөлбөр, чанар байдлыг боловсронгуй болгох замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ.
- 2.2.7. Орон сууц, нийтийн аж ахуйн бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгож хөгжиж буй орнуудын түвшинд хүргэнэ.
- 2.2.8. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүйн суурь судалгааг хөгжүүлж, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалтын үндэсний орон зайн мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлнэ.

2.3. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, үе шат:

Бодлогыг 2018-2028 он хүртэлх хугацаанд дараах үе шатаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1 дүгээр үе шат: (2018-2020 он) - Барилгын салбарын хямрал, хүндрэлийг даван, хөгжлийг тогтворжуулах үе
- 2 дугаар үе шат: (2021-2025 он) - Салбарын эрчимтэй хөгжлийн гарааны үе
- 3 дугаар үе шат: (2026-2030 он) - Хөгжингүй улс, орнуудын түвшинд хүрч, тогтворжих үе

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Салбарын удирдлага, зохион байгуулалт, хууль эрхзүй, норм, нормативыг боловсронгуй болгох замаар хөгжлийг хангана.

- 3.1.1. Салбарын удирдлага, зохион байгуулалтыг шинэ төлөв байдалд шилжүүлж, мэргэжлийн чадамж бүхий бүтцийг бий болгох бодлого, үйл ажиллагааны шинэчлэл хийнэ.
- 3.1.2. Салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 3.1.3. Салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгож өнөөгийн нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн түвшинд хүргэнэ.
- 3.1.4. Салбарын нэгдсэн цахим засаглалыг нэвтрүүлж, төлөвшүүлнэ.

3.2. Салбарын шинжлэх ухаан, технологийг хэрэгцээ шаардлагад нийцүүлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно.

3.2.1. Салбарын шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэхэд барилгын салбарын оролцоог нэмэгдүүлнэ.

3.2.2. Барилга, хот байгуулалтын салбарт эрдэм шинжилгээ, инновацийн бүтээгдэхүүний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэнэ.

3.3. Барилгын хөрөнгө оруулалтыг тэлж, салбарын үйл ажиллагааг олон улсын хөгжлийн жишигт нийцүүлнэ.

3.3.1. Барилгын салбарын хөгжлийн төлөвлөлтийн төсөөллөөр ДНБ-ний үйлдвэрлэлд эзлэх барилгын салбарын хувийн жинг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын өсөлтийг хангана.

3.3.2. Барилгын материалын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, үндсэн нэр төрлийн материалаар дотоодын хэрэгцээг хангана.

3.3.3. Зах зээлийн харилцааг боловсронгуй болгох, салбарын дотоодын зах зээлийн хамгаалалт, дархлааг дээшлүүлнэ.

3.4. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд суурилсан хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулах ажлыг олон улсын түвшинд хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.

3.4.1. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой төлөвлөлт, газрын харилцааг хөгжүүлж, хот, суурины оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ.

3.4.2. Хот төлөвлөлт, барилгын зураг төсөл боловсруулах ажлын төлөвлөлт, шийдэл, чанарыг сайжруулан, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангаж олон улсын түвшинд хүргэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.

3.5. Эх орны эрдэс баялгийн нөөцийг зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлж, салбарыг чанартай материалаар хангах бодлогыг тодорхойлно.

3.5.1. Барилгын материалын үйлдвэрийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

3.5.2. Барилгын материалын эрдэс түүхий эдийн хайгуул, судалгааг өргөжүүлэн нөөцөд авч шинэ технологи нэвтрүүлэх замаар материалын нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.5.3. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бизнесийн таатай орчин бүрдүүлнэ.

3.5.4. Барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаж тээвэр ложистик, ханган нийлүүлэлтийн талаар зохистой бодлого хэрэгжүүлнэ.

3.6. Салбарын мэргэжлийн сургалтын хөтөлбөр, чанар байдлыг боловсронгуй болгох замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлнэ.

3.6.1. Мэргэжлийн чадамж, үнэлгээ, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

3.6.2. Салбарын хөдөлмөрийн зах зээлийг хамгаалж, ажлын байрны тогтвортой байдлыг хангана.

3.7. Орон сууц, нийтийн аж ахуйн бодлого үйл ажиллагааг боловсронгуй болгож хөгжиж буй орнуудын түвшинд хүргэнэ.

3.7.1. Хот байгуулалтын бодлогод суурилсан орон сууцны үндэсний хөтөлбөрийг боловсруулж, дунд болон дундаас доош орлоготой зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хангалтыг нэмэгдүүлнэ.

3.7.2. Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлого батлуулан хэрэгжүүлнэ.

3.8. Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц, газар зохион байгуулалт, геодези зураг зүйн салбарын бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгон хөгжүүлнэ.

3.8.1. Улсын хэмжээнд газрын харилцаа, геодези зураг зүйн салбарын бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгон шинэчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Бодлогыг хэрэгжүүлснээр гарах үр нөлөө.

Монгол Улсын нийт хүн амд:

Хот суурингийн хүн амын орон сууцны хангамж мэдэгдэхүйц сайжирч нийт өрхийн 60 орчим хувь нь стандарт энгийн нөхцлөөс дээш үзүүлэлттэй нийтийн болон амины орон сууцаар хангагдаж, орон сууцны салбарт үл хөдлөх хөрөнгийн арилжааны зах зээл идэвхижинэ. Улсын хэмжээнд 1 хүнд ноогдох сууцны дундаж талбай 7.5 м² болно. Ажилгүйдлийн түвшин буурахад барилгын салбар мэдэгдэхүйц нөлөөлнө.

Барилгын салбарын төрийн байгууллагуудад:

Төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж, салбарын бодлого, үйл ажиллагааны шинэчлэлт 6 чиглэлд хийгдсэнээр төрийн оролцоо багасч, зохицуулалт сайжирч, орон тоо, зардал 20-30% багасна.

Барилгын салбарын төрийн бус байгууллагуудад:

Төр, хувийн хэвшлийн түншлэл жинхэнэ утгаараа хэрэгжиж, төрийн үйлчилгээ, төрийн захиалгыг ТББ-ууд гэрээлэн гүйцэтгэдэг журманд үндсэндээ бүрэн шилжинэ. ТББ-уудын мэргэжлийн болон санхүүгийн чадамж дээшилж, гишүүддээ үйлчилдэг үйлчилгээний чанар, хүртээмж мэдэгдэхүйц сайжирна.

Барилга угсралт болон барилгын материал үйлдвэрлэгчдэд:

Зах зээлийн арга хэрэгслээр бизнесээ хөгжүүлэх боломж нэмэгдэнэ, ажлын зах зээлд өрсөлдөх нөхцөл, шударга зарчим хэрэгжиж, дотоод, гадаадын хөрөнгө оруулах нөхцөл бүрдэж, бизнесээ итгэлтэй төлөвлөж, компани өргөжүүлэх, шинэ техник технологи эзэмших, бүтээгдэхүүнээ борлуулах менежмент, маркетингийн чөлөөт байдал бий болно. Барилгын зөвшөөрөл, бүртгэлийн тогтолцоонд шилжих, мэргэжлийн улсын хяналтын үйл ажиллагаа өмчийн эзний үүрэг хариуцлагад суурилсан зөвлөх үйлчилгээний хяналтад шилжиж төрийн хүнд суртал, чирэгдэл багасна.

Барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн цахим систем, нормчиллын нэгдсэн санг ашиглах эрх нээлттэй болж, тендерийн үнийн хэт ялгарал байхгүй, хүний оролцоо байхгүй болсноор шударга өрсөлдөөний нөхцөл бүрдэнэ.

Барилгын салбарын ханган нийлүүлэгчдэд:

Барилгын салбарын ханган нийлүүлэлтийн орчин үеийн боловсронгуй тогтолцоо болох “Бөөний сүлжээ, урьдчилан бэлтгэл, нөөцлөлтийн” зарчимд нийцсэн ханган нийлүүлэлтийн цахим худалдан авалтын боловсронгуй тогтолцоог Хөрөнгийн биржид

хувьцаа арилжих (IPO) замаар байгуулан төлөвшүүлснээр барилгын материалын үйлдвэрүүд, импорт-экспортын компаниуд улирлын хамаарлаас гарч, барилгын үнэ өртгийг 20%-иас доошгүй бууруулна.

Барилгын салбарт хэрэглэх нийт материал, бүтээгдэхүүний 86 орчим хувийг дотоодоосоо хангах зорилттой уялдан импортын хэмжээ мэдэгдэхүйц багасч, импортоор оруулах бараа бүтээгдэхүүний чанарт өндөр шаардлага тавигдахын зэрэгцээ, оюуны багтаамжтай шинэ техник, технологи, бүтээгдэхүүнийг оруулахад хөнгөлөлт урамшуулал бий болно. Эх орны үйлдвэрийн бүтээгдэхүүнтэй ижил нэрийн импортын бараа материалын татвар, тариф нэмэгдэнэ. Дотоодын эрдэс түүхий эд, эрчим хүч, усыг хэмнэлттэй ашигласан байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй “ногоон” материал, бүтээгдэхүүн, үйлдэрлэлийг урамшуулах механизм бүрдэнэ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчидэд:

Зөвшөөрөл, хяналтын хүнд сурталгүй болж, зах зээлийн нийтлэг горимоор үйл ажиллагаагаа чөлөөтэй эрхлэх өргөн боломж нээгдэж санхүү, эдийн засгийн хувьд бэхжиж, бизнесээ томруулах нөхцөл бүрдэнэ.

4.2. Бодлогын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт:

2017 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд бодлогын хэрэгжилтийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь оны үзүүлэлт	Зорилтот оны үзүүлэлт				Хэрэгжүүлэх байгууллага
		2017	2020	2024	2028		
Салбарын хууль эрхзүй, норм, нормативын зохицуулалтын хүрээнд							
Боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах хуулийн тоо		5					
ЗГ, БХБС-ын тушаалаар батлагдсах дүрэм журам	ширхэг	34	34	-	-		
Техникийн зохицуулалтын тоо	ширхэг	-	1	2	3	БХБЯ СХЗГ	
Норм, нормативын баримт бичгийн боловсруулалтын түвшин	%	27 ²	40	60	80		
Олон улсын түвшинд хүргэх стандартын тоо	%	55	60	70	80	БХБЯ СХЗГ	
Барилгын зах зээлийн хөгжлийн чиглэл, хөрөнгө оруулалт							

² “Барилгын норм дүрэмд үзлэг хийж техникийн түвшин тогтоох” зөвлөх үйлчилгээний тайлан,

Ашиглалтад оруулсан орон сууцны тоо						
Инженерийн дэд бүтцэд хамрагдсан айл өрхийн тоо						
Барилгын дулааны алдагдлын бууралт, хувь			20		40	
Барилгын үйлдвэрлэлд нэвтэрсэн байх технологийн дэвшил	Технологийн нэр	Бүрэн цутгамал, Араг бүтээцэт цутгамал	Угсармал, цутгамал хослосон hybrid			
Барилгын зураг төсөл, архитектур, хот төлөвлөлтийн хөгжлийн чиглэл						
ВIM-ийн тогтолцоо					Бүрэн нэвтэрсэн байна	
Барилгын материалын эрдэс баялгийн нөөц, үйлдвэрлэл, хангамжийн балансжилт, импорт, экспортын чиглэл						
Дотоодын нийт бүтээгдэхүүнд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь			28		30	
Барилгын материалын үйлдвэрлэлийн хэмжээ						
БМ-ын импортын хэмжээ						
Салбарын сургалт, хүний нөөцийн хөгжлийн чиглэл						
Барилгын салбарын мэргэжилтэй ажиллах хүчний тоо						
Салбарын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн тоо						
Салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл						

Шинээр гарган авах материалын тоо						
Лабораторийн хүчин чадал						

Суурь түвшинийг тодорхойлсон мэдээллийн эх сурвалжийг бичнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ.

БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг дараах хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 5.1 Улсын болон орон нутгийн төсөв;
- 5.2 Барилга, байгууламжийн норм, нормативын сан; /Барилгын тухай хуульд заасан хүрээнд/
- 5.3 Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- 5.4 Аж ахуйн нэгж, байгууллагаас гаргах хөрөнгө;
- 5.5 Бусад эх үүсвэр.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 6.1 Бодлогын хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, түүний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах ажлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.
- 6.2 Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжилтийн явцын тайланг жил бүрийн эхний хагас жилд багтаан холбогдох яам, агентлагуудаас авч, дүгнэн Засгийн газарт 2 жил тутам танилцуулж байна.
- 6.3 Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь салбарын хэмжээнд зохион байгуулагддаг мэргэжлийн хурал, чуулганд бодлогын явц, үр дүнгийн талаар танилцуулах, шаардлагатай тохиолдолд бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Монгол Улсын Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлнэ.

--- оОо ---